

АНГЛИ ХЭЛНИЙ БАГ ОЛИМПИАД БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ

Ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний хичээлийн агуулгыг бататгах, суралцагчдын англи хэлний чадварыг нэмэгдүүлэх, олон улсын олимпиадад бэлтгэх зорилгоор Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн нэрэмжит англи хэлний “CROWN” БАГ ОЛИМПИАД өнөөдөр 3 дугаар сарын 28-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа.

Олимпиадад аймгийн 15 сургуулийн 6-11 дүгээр ангийн 81 багийн 486 сурагч оролцож англи хэлний сонсох, унших, хэлний хэрэглээний чадвараа сорилоо. Тус олимпиад нь европын холбооны хэлний стандартын сурах бичгийн агуулгын хүрээнд зохион байгуулагдаж байгаагаараа онцлог юм. Дүнг жагсаавал:

1 дүгээр байр – 8 дугаар сургууль

2 дугаар байр – 1 дүгээр сургууль

3 дугаар байр – 5 дугаар сургууль

АНГЛИ ХЭЛНИЙ 6 ДУГААР АНГИЙН ТӨРӨЛД:

1-р байр 1 дүгээр сургуулийн 1 дүгээр баг /Бэлтгэсэн багш: Г. Эрдэнэ /

2-р байр 8 дугаар сургуулийн 1 дүгээр баг / Бэлтгэсэн багш: Н. Цэцэгмаа/

3-р байр 8 дугаар сургуулийн 2 дугаар баг / Бэлтгэсэн багш: О. Саранцэцэг/

АНГЛИ ХЭЛНИЙ 7 ДУГААР АНГИЙН ТӨРӨЛД:

1-р байр 8 дугаар сургуулийн 1 дүгээр баг /Бэлтгэсэн багш: Д. Сарнай /

2-р байр 1 дүгээр сургуулийн 1 дүгээр баг / Бэлтгэсэн багш: Г. Саранцимэг /

3-р байр 5 дугаар сургуулийн 1 дугаар баг / Бэлтгэсэн багш: Б. Бямбасүрэн /

АНГЛИ ХЭЛНИЙ 8 ДУГААР АНГИЙН ТӨРӨЛД:

1-р байр 8 дугаар сургуулийн 1 дүгээр баг /Бэлтгэсэн багш: С. Түвшинтуяа /

2-р байр 1 дүгээр сургуулийн 1 дүгээр баг / Бэлтгэсэн багш: М. Мөнхтуул /

3-р байр 8 дугаар сургуулийн 3 дугаар баг / Бэлтгэсэн багш: Н. Анужин /

АНГЛИ ХЭЛНИЙ 10 ДУГААР АНГИЙН ТӨРӨЛД:

1-р байр 5 дугаар сургуулийн баг /Бэлтгэсэн багш: Б. Ууганцэцэг /

2-р байр Долоодой сургуулийн баг / Бэлтгэсэн багш: О. Баасанжаргал/

3-р байр 8 дугаар сургуулийн 1 дүгээр баг / Бэлтгэсэн багш: О. Саранцэцэг /

АНГЛИ ХЭЛНИЙ 11 ДҮГЭЭР АНГИЙН ТӨРӨЛД:

1-р байр 5 дугаар сургуулийн 1 дүгээр баг /Бэлтгэсэн багш: / Т. Гэрэлмаа /

2-р байр 8 дугаар сургуулийн 1 дүгээр баг / Бэлтгэсэн багш: Э. Уянга/

3-р байр Долоодой сургуулийн баг / Бэлтгэсэн багш: О. Баасанжаргал/

Сумдын хувьд “Өндөр оноо”ны үзүүлэлтээр Чулуун хороот ЕБС, “Хамгийн олон оролцогч оролцсон сургууль”-аар Цагаан овоо ЕБС шалгарсан байна.

Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар нь олимпиадад шавиа сайн бэлтгэсэн 15 багшийг “Interprise” номын эрхээр шагнаж урамшууллаа. Олимпиадыг санаачилж зохион байгуулсан 8 дугаар сургуулийн баг хамт олон, багш нар, дэмжиж оролцон мэдлэг оюунаа сорьсон нийт сурагчиддаа талархал илэрхийлье.

Мэдээлэл бэлтгэсэн. Ахлах арга зүйч Ө.Болорчимэг